



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/127/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
4.3 Албан шаардлага	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.02.25 № 45
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Н.БАДАМЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ 0012020783

Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>40,793,174.00</u>	<u>117,146,270.13</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	32,955,685.96
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	32,955,685.96
3121	Төгрөг	-	32,955,685.96
31211	Төрийн сангийн харилцах	-	1,900,629.89
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	31,055,056.07
33	АВЛАГА	2,635,635.44	18,475,535.44
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	18,128,700.00
335	Бусад авлага	1,736,635.44	346,835.44
3351	Байгууллагаас авах авлага	1,736,635.44	346,835.44
35	БАРАА МАТЕРИАЛ	38,157,538.56	65,715,048.73
351	Түүхий эд материал	24,008,180.58	36,602,144.75
35110	Тусгай зориулалттай материал	6,009,649.43	13,405,090.05
35130	Эм боох материал	17,998,531.15	23,197,054.70
354	Хангамжийн материал	14,149,357.98	29,112,903.98
35410	Бичиг хэргийн материал	296,500.00	614,000.00
35420	Аж ахуйн материал	9,265,382.98	20,631,382.98
35440	Түлш, шатах тослох материал	2,515,240.00	2,098,511.00
35450	Барилгын засварын материал	-	1,785,000.00
35460	Хүнсний материал	2,072,235.00	3,984,010.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>457,991,082.81</u>	<u>523,041,193.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	457,991,082.81	523,041,193.34
392	Биет хөрөнгө	447,047,082.81	512,097,193.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	405,685,839.40	415,585,839.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,775,011.64)	(38,055,095.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,560,000.00	34,560,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,455,833.39)	(13,205,833.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,169,430.16	132,733,933.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,780,435.62)	(31,792,798.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,145,677.39	22,550,676.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,502,583.49)	(10,279,527.34)
393	Биет бус хөрөнгө	10,944,000.00	10,944,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,944,000.00	10,944,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>498,784,256.81</u>	<u>640,187,463.47</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>498,784,256.81</u>	<u>640,187,463.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	498,784,256.81	640,187,463.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	538,511,783.69	538,511,783.69
51101	Өмч: - төрийн	538,511,783.69	538,511,783.69
512	Хуримтлагдсан үр дүн	(159,770,274.91)	(18,367,068.25)
51210	Өмнөх үеийн үр дүн	(159,770,274.91)	(159,770,274.91)
51220	Тайлант үеийн үр дүн	-	141,403,206.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,042,748.03	120,042,748.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>498,784,256.81</u>	<u>640,187,463.47</u>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
төгрөгөөр**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	389,227,317.85	818,137,450.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,692,347.85	196,234,500.21
120	Нийтлэг татварын бус орлого	29,692,347.85	196,234,500.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,692,347.85	196,234,500.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	630,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,692,347.85	195,604,500.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359,534,970.00	621,902,950.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	307,773,500.00	338,291,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307,773,500.00	338,291,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	239,350,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	25,200,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		214,150,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,472,100.00	35,571,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,472,100.00	35,571,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,289,370.00	8,690,350.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,289,370.00	8,690,350.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	392,885,220.72	676,734,243.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	392,885,220.72	676,734,243.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,462,167.56	644,947,443.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,706,189.22	273,245,025.77
210101	Үндсэн цалин	146,510,391.33	139,074,700.00
210102	Нэмэгдэл	58,546,004.10	82,349,862.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,825,223.00	3,661,997.70
210104	Урамшуулал	19,824,570.79	48,158,465.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,397,407.33	32,624,142.67
210201	Тэтгэврийн даатгал	18,564,610.56	22,704,508.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,125,736.65	2,629,233.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,794,787.12	2,096,647.00
210204	Ажилгүйдлийн даатгал	425,045.00	467,887.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,487,228.00	4,725,867.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,662,596.85	31,526,203.00
210301	Гэрэл, цахилгаан	2,960,765.96	2,924,193.00
210302	Түлш, халаалт	25,701,830.89	28,602,010.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,093,480.14	29,206,629.52
210401	Бичиг хэрэг	1,220,900.00	1,073,050.00

210402	Тээвэр, шатахуун	16,788,380.00	22,622,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	684,530.00	791,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000.00	919,019.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,579,800.00	3,801,139.64
2105	Нормативт зардал	41,067,662.20	223,251,634.96
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,355,460.20	217,781,954.96
210502	Хоол, хүнс	5,712,202.00	5,469,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,892,100.00	4,437,450.00
210604	Урсгал засвар	2,541,100.00	4,437,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	2,380,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	2,380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,780,672.00	2,438,781.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	528,800.00	1,034,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	155,000.00	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,900.00	61,205.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	570,000.00
210807	Газрын төлбөр	116,172.00	43,776.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	299,800.00	570,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,062,059.82	45,837,576.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,106,039.40	6,704,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,956,020.42	39,133,476.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,423,053.16	31,786,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	31,786,800.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	3,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	25,200,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,586,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(3,657,902.87)</u>	<u>141,403,206.66</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(3,962,902.94)</u>	<u>141,403,206.66</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>359,534,970.00</u>	<u>604,404,250.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	630,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	630,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	630,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	630,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359,534,970.00	603,774,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	307,773,500.00	338,291,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307,773,500.00	338,291,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	221,221,300.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	25,200,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		196,021,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,472,100.00	35,571,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,472,100.00	35,571,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,289,370.00	8,690,350.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,289,370.00	8,690,350.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>353,669,970.00</u>	<u>547,933,564.04</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,669,970.00	547,933,564.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,246,916.84	516,146,764.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,635,039.22	272,346,025.77
210101	Үндсэн цалин	150,147,545.43	138,175,700.00
210102	Нэмэгдэл	55,837,700.00	82,349,862.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,825,223.00	3,661,997.70
210104	Урамшуулал	19,824,570.79	48,158,465.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,469,042.77	32,624,142.67
210201	Тэтгэврийн даатгал	18,636,246.00	22,704,508.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,125,736.65	2,629,233.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,794,787.12	2,096,647.00
210204	Ажилгүйдлийн даатгал	425,045.00	467,887.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,487,228.00	4,725,867.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,662,596.85	31,526,203.00
210301	Гэрэл, цахилгаан	2,960,765.96	2,924,193.00
210302	Түлш, халаалт	25,701,830.89	28,602,010.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,114,010.00	32,664,341.00
210401	Бичиг хэрэг	915,900.00	1,491,650.00
210402	Тээвэр, шатахуун	17,303,480.00	21,923,791.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	684,530.00	791,300.00
210404	Ном, хэвлэл	-	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	244,600.00	2,726,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,965,500.00	5,611,000.00
2105	Нормативт зардал	30,948,056.00	124,635,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,836,694.00	114,720,405.00
210502	Хоол, хүнс	5,775,362.00	6,768,215.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,336,000.00	3,147,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,977,100.00	10,667,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,216,000.00	230,000.00
210604	Урсгал засвар	4,508,100.00	10,437,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	2,380,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	2,380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,780,672.00	2,612,881.60

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	528,800.00	1,034,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	155,000.00	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,900.00	61,205.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	620,100.00
210807	Газрын төлбөр	116,172.00	43,776.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	299,800.00	694,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,860,400.00	6,690,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,860,400.00	6,690,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,423,053.16	31,786,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	31,786,800.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	3,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	25,200,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,586,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,865,000.00</u>	<u>56,470,685.96</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,865,000.00	23,515,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,865,000.00	23,515,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,865,000.00	23,515,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,865,000.00	23,515,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,865,000.00)</u>	<u>(23,515,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	32,955,685.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		32,955,685.96

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-155,807,371.97	502,747,159.75
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-155,807,371.97	502,747,159.75
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,962,902.94	-3,962,902.94
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-159,770,274.91	498,784,256.81
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-159,770,274.91	498,784,256.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-159,770,274.91	498,784,256.81
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	141,403,206.66	141,403,206.66
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	538,511,783.69	120,042,748.03	-18,367,068.25	640,187,463.47

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
төгрөгөөр**

	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	395,769,900.00	380,652,320.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	395,769,900.00	380,652,320.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,944,900.00	374,065,520.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,660,900.00	245,882,159.84
210101	Үндсэн цалин	138,175,700.00	138,175,700.00
210102	Нэмэгдэл	83,026,600.00	82,349,862.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,764,000.00	3,661,997.70
210104	Урамшуулал	21,694,600.00	21,694,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,123,500.00	31,361,460.67
210201	Тэтгэврийн даатгал	22,619,600.00	21,857,560.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,525,300.00	2,525,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,013,500.00	2,013,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	447,100.00	447,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,518,000.00	4,518,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,133,700.00	31,133,532.00
210301	Гэрэл, цахилгаан	2,531,600.00	2,531,522.00
210302	Түлш, халаалт	28,602,100.00	28,602,010.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,108,100.00	26,103,741.00
210401	Бичиг хэрэг	1,042,300.00	1,042,050.00
210402	Тээвэр, шатахуун	21,924,000.00	21,923,791.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	795,200.00	791,300.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	826,600.00	826,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400,000.00	1,400,000.00
2105	Нормативт зардал	37,032,200.00	23,814,195.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,414,800.00	17,197,195.00
210502	Хоол, хүнс	3,470,000.00	3,470,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,147,400.00	3,147,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,437,500.00	4,437,450.00
210604	Урсгал засвар	4,437,500.00	4,437,450.00
2107	Томилолт, зочны зардал	2,480,000.00	2,380,000.00
210702	Дотоод албан томилолт	2,480,000.00	2,380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,269,000.00	2,262,881.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,034,800.00	1,034,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	159,000.00	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,300.00	61,205.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	270,100.00	270,100.00
210807	Газрын төлбөр	43,800.00	43,776.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700,000.00	694,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,700,000.00	6,690,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,700,000.00	6,690,100.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,825,000.00	6,586,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,825,000.00	6,586,800.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	3,000,000.00	3,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,825,000.00	3,586,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,478,400.00	44,261,550.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,571,200.00	35,571,200.00
122005	Орон нутгийн төсвөөс	35,571,200.00	35,571,200.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	21,907,200.00	8,690,350.00
122001	Хандив тусламж /дотоод/	21,907,200.00	8,690,350.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,900,629.89

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	190,796,243.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	190,796,243.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	165,596,243.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,463,865.93
210104	Урамшуулал	26,463,865.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,262,682.00
210201	Тэтгэврийн даатгал	846,948.00
210202	Тэтгэмжийн даатгал	103,933.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	83,147.00
210204	Ажилгүйдлийн даатгал	20,787.00
210205	Эрүүл мэндийн даатгал	207,867.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	392,671.00
210301	Гэрэл, цахилгаан	392,671.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,560,600.00
210401	Бичиг хэрэг	449,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,211,000.00
2105	Нормативт зардал	100,821,425.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	97,523,210.00

210502	Хоол, хүнс	3,298,215.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,745,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,745,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	221,851,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	221,851,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	630,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	196,021,300.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,055,056.07

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 19-ний өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо “Хүн амд хөнгөн шуурхай найдвартай соёл ч үйлчилгээг үзүүлнэ. Эмч мэргэжилтний чадавх хандлагыг

дээшлүүлэх үйлчлүүлэгчдэд ээлтэй тэгш чанартай туслахаар үйлчилгээг хүргэх сумын нийт хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино.” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтаар албан томилолын журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 676,734.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,767.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,737.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 141,403.2 мянган төгрөгөөр буюу 28.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	32,955.7	32,955.7
Авлага	2,635.6	18,475.5	15,839.9
Бараа материал	38,157.5	65,715.0	27,557.5
Үндсэн хөрөнгө	457,991.1	523,041.2	65,050.1
Нийт хөрөнгө	498,784.2	640,187.4	141,403.2
			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	498,784.2	640,187.4	141,403.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	498,784.2	640,187.4	141,403.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 32,955.7 мянган төгрөг болж өссөн нь 1,900.6 мянган байгууллагын үндсэн үйл ажиллагаа, 31,055.1 мянган төгрөгийн ковидын хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилтийн үлдэгдэл тус тус байна.

Авлага данс өмнөх оноос 15,839.9 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалаас авах хэвтэн эмчлүүлэгчдийн үйлчилгээний орлогын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 65,715.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 27,557.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 165,961.4 мянган төгрөг, хандив тусламжаар ирсэн 116,600.9 мянган төгрөг, нийт 282,562.3 мянган төгрөгийн аж ахуйн материалын өсөлт нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 65,715.0 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн нь ковид-19 цар өвчин гарсантай холбоотойгоор тусгаарлах байр тохижуулах зардал, эм, боох материал, эмнэлгийн хэрэгслийн материалыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд хандиваар 79,003.6 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 25,180.0 мянган төгрөгийн хөрөнгийг зохих дансанд бүртгэж, 2,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, 8,314.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 640,187.4 мянган төгрөг болж 141,403.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 395,769.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 395,769.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг дээрх дүнгээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 395,769.9 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 380,652.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 13,217.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан нь үндсэн үйл ажиллагааны 4 тусламж үйлчилгээг ковидын нөхцөл байдлаас шалтгаалж дутуу үзүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 380,652.3 мянган төгрөг буюу 96.2 хувийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 1,900.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 221,221.3 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 630.0 мянган төгрөг, нийт 221,851.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 6,560.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 29,745.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 350.0 мянган төгрөг, норматив зардалд 100,821.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 25,200.0 мянган төгрөг, байр ашиглалтын зардалд 392,7 мянган төгрөг, цалингийн зардалд 26,463.9 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1,262.6 мянган төгрөг нийт 190,796.2 мянган төгрөгийг зарцуулж, 31,055.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид-19 цар тахал тархсантай холбоотой тайлант онд тусламж хандив, төсвийн өөрийн хөрөнгөөр нийт 218,766.9 мянган төгрөгөөр эм боох материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, эмийн багц, ковидын тест, дархлаажуулалтын вакцин худалдан авч, 208,515.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилсэн 90 ширхэг эмийн үнийн зөрүү 1,158.2 мянган төгрөгийн, тусгай зориулалтын материалын 6,200.4 мянган төгрөгийн орлогыг бараа материалын дансанд бүртгээгүй алдааг тус тус аудитын явцад залруулсан.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 679,518.6 мянган төгрөгийн 128 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулснаас 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн 2,855.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 434.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 124.8 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13,012.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,545.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,467.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн өглөгийг тайланд анхан шатны баримтаас 186.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
2. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 1,158.2 мянган төгрөгөөр зөрүүтэй дүнгээр нэхэмжилсэн.
3. Тусгай зориулалтын материалын 6,200.4 мянган төгрөгийн орлогыг бараа материалын дансанд бүртгээгүй

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар 186.5 мянган төгрөг, жилийн эцсийн санхүүгийн аудитын явцад 7,358.5 мянган төгрөг, нийт 7,545.0 мянган төгрөгийн алдааг залруулсан хийсэн.

4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Гаднын машинтай гэрээ хийлгүй, анхан шатны баримт дутуу, шатахууны зарим зөвшөөрлийн хуудаст тамга тэмдэг дараагүй, 2,855.6 мянган төгрөгийн түлш, шатахууныг зарцуулсан.
2. Санхүүгийн тайланд гэрэл цахилгааны 316.7 төгрөг, түлш халаалтын 1,968.0 мянган төгрөгийн зардлуудыг анхан шатны баримтаас зөрүүтэй тайлагнасан.

3. Ковидын урамшуулал цалингаас төлөх 327.3 мянган төгрөгийн НДШ-ийг үндсэн дансны зардлаас төлсөн.

Шийдвэрлэсэн нь: Нийт 5,467.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Завсрын аудитаар хүргүүлсэн 5,140.3 мянган төгрөгийн албан шаардлагын хариу ирүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Залруулга				Төлбөрийн акт		Албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Гаднын машинтай гэрээ хийлгүй, анхан шатны баримт дутуу, шатахууны зарим зөвшөөрлийн хуудаст тамга тэмдэг дараагүй, түлш, шатахууныг зарцуулсан.							1	2,855.6		
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг зөрүүтэй дүнгээр нэхэмжилсэн.			1	186.5						
2	Санхүүгийн тайланд гэрэл цахилгааны 316.7 төгрөг, түлш халаалтын 1,968.0 мянган төгрөгийн зардлуудыг анхан шатны баримтаас зөрүүтэй тайлагнасан							1	2,284.7		
3	Ковидын урамшуулал цалингаас төлөх НДШ-ийг үндсэн цалингийн зардлаас төлсөн.							1	327.3		
4	Тусгай зориулалтын материалын орлогыг бараа материалын дансанд бүртгээгүй			1	6,200.3						
5	Хуваарилсан эмний нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас буруу дүнгээр тайлагнасан.			1	1,158.2						
Нийт зөрчлийн дүн		6	13,012.6	3	7,545.0	-	-	3	5,467.6		